# ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ. Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний зохицуулалтын үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгоно. | | | | | | | |
| 1.1 | “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийг шинэчлэн найруулах ажлын хэсгийг мэдээллээр хангаж хамтран ажиллана. | 5 сая Улсын төсөв | Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо | “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийг шинэчлэн найруулах ажлын хэсэгтэй хамтран нийт 22 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. | “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийг шинэчлэн найруулах ажлын хэсгийг мэдээллээр хангаж, уулзалт хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулсан байна. | Хамтран зохион байгуулсан, оролцсон уулзалт, хэлэлцүүлэг-10<br>“Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулах нэгдсэн ажлын хэсэг ЭМ-ийн Сайдын 2022.06.23-ны өдрийн А/330 дугаар тушаалаар байгуулагдаж, ЭМЯ, АХБ-ны Халдварт бус өвчний хяналт, эмийн аюулгүй байдлыг сайжруулах МОН-6652 төслийн багтай хамтран 5 удаагийн хурал, хэлэлцүүлэг, ЭМЯ-ны дэд ажлын хэсгийн хурал-3, ЭЭХХЗГ-ын дэд ажлын хэсгийн хурал-2 тус тус зохион байгуулж, оролцож, ажилласан.<br>Доорх мэдээллүүдийг ажлын хэсэгт хүргүүлсэн. Үүнд:<br>- Төрөөс эмийн үнийг зохицуулах аргууд, ДЭМБ-ын удирдамж<br>- Нэгдсэн худалдан авалтын олон улсын туршлага, НҮБХС-гийн эмийн худалдан авалтын тогтолцоо<br>- Монгол улсын өнөөгийн байдал, Ерөнхий гэрээний худалдан авалтын тоон мэдээ<br>- Эрүүл мэндийн яам болон Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын үүрэг<br>ЭЭХХЗГ-ын даргын 2022.09.23-ны өдрийн А/181 дүгээр тушаалаар батлагдсан дэд ажлын хэсгээс доорх 2 багц саналуудыг хүргүүлсэн. Үүнд:<br>- “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийн төслийн үзэл баримтлал, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх саналыг ЭМЯ-ны ТНБД-д 2022.10.31-ний 01/2089 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Хуулийн үзэл баримтлалын төслийн саналыг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, ЭМЯ-нд 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/2217 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | |
| 1.2 | ЗГҮАХ-ийн 2.1.8, МУХТЖҮЧ-ийн 2.2.7.<br><br>Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын лиценз олгох журмын төслийг шинэчлэн боловсруулна. | - | Шинэчлэн боловсруул сан журмын төсөл | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/407 дугаар тушаал "Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын лиценз олгох журам"-ыг мөрдөн ажиллаж байна. | "Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын лиценз олгох журам"-ыг шинэчлэн боловсруулж, төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | "Эм, эмнэлгийн хэрэгслийн импорт, экспортын лиценз олгох" журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг 2022.04.06-ны өдрийн А/65 тоот тушаалаар батлуулж, санал авахаар дараах газруудад шинэчилсэн журмын төсөл хүргүүлсэн.<br>Уулзалт-1<br>- Эм ханган нийлүүлэх 31 байгууллагатай 2022 оны 9 дүгээр сарын 02-ны өдөр уулзалт зохион байгуулж, журмын төсөлд санал авсан.<br>ЭМЯ-нд хүргүүлсэн санал-1<br>- Ирсэн бүх саналыг журмын төсөлд тусгаж, даргын зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар танилцуулж, 2022 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 01/2302 албан тоотоор ЭМЯ-нд хүргүүлсэн. | 100% |
| 1.3 | ЗГҮАХ-ийн 2.1.8, МУХТЖҮЧ-ийн 2.2.7.<br><br>Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний тусгай зөвшөөрлийн зохицуулалтын журмыг шинэчлэн боловсруулна. | - | Шинэчлэн боловсруул сан журмын төсөл | Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 264 дүгээр "Шалгуур батлах тухай" тушаалыг мөрдөн ажиллаж байна. | Журмыг шинэчлэн боловсруулж, төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | "Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний тусгай зөвшөөрлийн зохицуулалтын журам"-ын шинэчлэн боловсруулсан төсөл-1<br>- Ажлын хэсэг 2021.04.08-ны өдрийн А/23 дугаар тушаалаар байгуулагдсан. Нийт 6 удаагийн хурлаар журмын төсөл болон ЭМ-ийн Сайдын 2015 оны 264 дүгээр тушаал, ажлын байрны үнэлгээ шалгуур шинэчлэн батлах талаар санал авч, журмын төслийг даргын зөвлөлийн 2022.03.10-ны өдрийн хуралд танилцуулсан.<br>- ДЭМБ-ын санхүүжилтээр хэлэлцүүлэг 2022.06.20-ны өдөр зохион байгуулсан.<br>- "Журам шинэчлэн батлах тухай" ЭМС-ын 2021 оны А/400 дугаар тушаалд нэмэлт өөрчлөлт оруулан саналыг 2022.09.12-нд 01/1782 дугаар албан бичгээр ЭМЯ-нд хүргүүлж, 2022.09.27-ны өдрийн А/480 дугаар тушаалаар батлагдсан. | 100% |
| 1.4 | "Фармакопей боловсруулах, батлах, дугаар | - | Шинэчлэн боловсруул | Эрүүл мэндийн сайдын 2014 оны 132 дугаар | "Фармакопей боловсруулах, батлах, дугаар өгөх, | Шинэчлэн боловсруулсан журмын төсөл-1<br>Журмын төслийг боловсруулах ажлын хэсэг 2022.06.16-ны өдрийн А/132 дугаар тушаалаар шинэчилсэн ажлын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өгөх, фармакопейн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам"-ыг шинэчлэн боловсруулна. | | сан журмын төсөл | тушаалыг мөрдөн ажиллаж байна. | фармакопейн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам"-ыг шинэчлэн боловсруулж, төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | хэсгийг А/205 дугаар тушаалаар баталсан. Тус ажлын хүрээнд доорх ажлыг хийсэн. Үүнд:<br>- ДЭМБ-ын "WHO Technical Report Series No. 996, 2016 "Good pharmacopoeial practices" удирдамжийг орчуулж, журмын төсөлд тусгах шаардлагатай, холбогдох зүйл, заалтыг оруулсан.<br>- Иргэдээс санал авахаар шинэчилсэн журмын төслийг 2022.11.18-ны өдөр байгууллагын цахим хуудсанд байршуулсан.<br>Шинэчлэн боловсруулсан журмын төслийг Фармакопейн хорооны 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, гишүүдийн санал, зөвлөмжийг тусгасан. ЭЭХХЗГ-ын Даргын зөвлөлийн 2022.12.14-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, ЭМЯ-нд 01/2316 дугаар албан бичгээр хүргүүлсэн | |
| 1.5 | ЗГҮАХ-ийн 2.1.8, МУХТЖҮЧ-ийн 2.2.7.<br><br>Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх журмыг шинэчлэн боловсруулна. | - | Шинэчлэн боловсруул сан журмын төсөл | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/295 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөн ажиллаж байна. | Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх журмыг шинэчлэн боловсруулж, төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | Шинэчлэн боловсруулсан журмын төсөл-1<br>"Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх" журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг ЭЭХХЗГ-ын Даргын 2022 оны А/44 дүгээр тушаалаар байгуулж, бүртгэлийн үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудал, одоогийн мөрдөж байгаа журмын маргаан үүсгэж байгаа заалтуудыг дахин найруулсан. Мөн гамшиг, НЭМ-ийн ноцтой байдлын үед эмийг зах зээлд нэвтрүүлэх, зохицуулалтыг тусгахаар АНУ, Япон, Европын холбооны улсын зохицуулалтыг судлан журмын төслийг шинээр боловсруулсан. Журмын төслийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд 6 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үүнд:<br>- Ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион байгуулж, 22 санал авч, журамд 7 саналыг тусгасан.<br>- ЭЭХХЗГ-ын бүх газар, хэлтсийн төлөөлөл, АХБ-ны Халдварт бус өвчний хяналт, эмийн аюулгүй байдлыг сайжруулах МОН-6652 төслийн зөвлөх оролцсон хэлэлцүүлгийг 2022.10.11-ний өдөр зохион байгуулж, 5 санал гарсныг журмын төсөлд тусгасан.<br>- Бүртгэлийн шинжээчдэд зориулсан 2 удаагийн сургалтад шинэчилсэн журмын төслийг танилцуулсан.<br>ЭМЯ-нд хүргүүлсэн төсөл-1 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ЭЭХХЗГ-ын Даргын зөвлөлийн 2022.12.08-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, ЭМЯ-нд 2022.12.13-ны өдрийн 01/2315 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | |
| 1.6 | Бүртгэлийн шинжээчийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | - | Шинэчлэн батлуулсан журам | Эрүүл мэндийн сайдын 2015 оны 225 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөн ажиллаж байна. | Бүртгэлийн шинжээчийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулж, төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | Шинэчлэн боловсруулсан журмын төсөл-1<br>- Бүртгэлийн шинжээчийг ажиллуулах журмын төслийг ДЭМБ-ын Ерөнхий нэршлийн эмийг зах зээлд гаргах үйл ажиллагааны зөвлөмж, ASEAN-ий "Common Technical Document" зэрэг олон улсын удирдамж, зааврыг Монгол улсын хууль, эрх зүйн зохицуулалтад нийцүүлэн боловсруулсан.<br>- Бүртгэлийн шинжээч нараар 2022.01.04, 2022.01.07-ны өдөр, ЭЭХХЗГ-ын Даргын зөвлөлийн 2022.03.31-ний өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлсэн.<br>- Иргэдээс шинэчилсэн журмын төсөлд санал авахаар 2022.08.05-ны өдрөөс байгууллагын цахим хуудсанд сарын хугацаатай байршуулсан.<br>ЭМЯ-нд хүргүүлсэн төсөл-1<br>Шинэчилсэн журмын төслийг ЭМЯ-нд 2022.10.22-ны өдрийн 01/2012 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Батлагдсан журам-1<br>ЭЭХХЗГ-ын Даргын 2022 оны А/233 дугаар тушаалаар "Бүртгэлийн шинжээчийг ажиллуулах журам"-ыг баталсан. | 100% |
| 1.7 | ЗГҮАХ-ийн 2.1.8, МУХТЖҮЧ-ийн 2.2.7.<br><br>Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааг зохицуулах үйл ажиллагааны журмыг шинээр боловсруулна. | - | Шинээр боловсруулсан журмын төсөл | - | Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааг зохицуулах үйл ажиллагааны журмыг шинээр боловсруулж, төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | Шинэчлэн боловсруулсан журмын төсөл-1<br>Журмын төслийг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн ЭМ-ийн Сайдын 2015 оны 284 дугаар тушаалаар батлагдсан "Гадаад, дотоодын эм үйлдвэрлэгчийн төлөөлөгчийн газрын ажиллах журам"-тай нэгтгэн, шинэчлэн боловсруулсан.<br>Төсөлд газар, хэлтсийн дарга нарын саналын тусган, ЭЭХХЗГ-ын Даргын зөвлөлийн 2022.12.08-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн.<br>Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.8 дах заалтыг үндэслэн даргын зөвлөлийн хурлаас гарсан саналыг тусгаж, ЭЭХХЗГ-ын даргын 2022 оны А/236 дугаар тушаалаар батлуулсан. | 100% |
| 1.8 | Зах зээл дэх эм, эмнэлгийн хэрэгсэлд | - | Шинэчлэн батлуулсан журам | Эрүүл мэндийн сайдын 2014 оны 33 дугаар тушаалаар | Зах зээл дэх эм, эмнэлгийн хэрэгсэлд тандалт судалгааг | Шинэчлэн боловсруулсан тушаалын төсөл-1<br>- ДЭМБ-ын Эмийн бүтээгдэхүүний техникийн шаардлагын шинжээчдийн хорооны 2016 оны | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тандалт судалгааг хийх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | | | батлагдсан журмыг мөрдөн ажиллаж байна. | хийх журмыг шинэчлэн боловсруулж, төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | техникийн тайлангийн “Эмийн чанарын судалгаа хийх удирдамж”-ийг орчуулан журмын төсөлд оруулсан.<br>- Иргэдээс шинэчилсэн журамд санал авахаар 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр байгууллагын цахим хуудсанд сарын хугацаатай байршуулж, нөлөөллийн шинжилгээг хийсэн.<br>ЭМЯ-нд хүргүүлсэн төсөл-1<br>Шинэчилсэн журмын төслийг 01/2090 албан тоотоор 2022 оны 10 дугаар сарын 31-ны өдөр ЭМЯ-нд хүргүүлсэн. | |
| 1.9 | Эм, вакцины гаж нөлөө болон аюулгүй байдлын тайланг бүртгэн мэдээлэх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | - | Шинэчлэн батлуулсан журам | Эрүүл мэндийн сайдын 2013 оны 415 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөн ажиллаж байна. | Эм, вакцины гаж нөлөө болон аюулгүй байдлын тайланг бүртгэн мэдээлэх журмыг шинэчлэн боловсруулж, төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | Шинэчлэн боловсруулсан тушаалын төсөл-1<br>- “Эмийн гаж нөлөө, аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн, мэдээлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, нөлөөллийн шинжилгээ хийсэн.<br>- Иргэдээс шинэчилсэн төсөлд санал авахаар төслийг байгууллагын цахим хуудсанд 2022.02.11-ний өдөр сарын хугацаатай байршуулж, нөлөөллийн шинжилгээ хийсэн.<br>ЭМЯ-нд хүргүүлсэн төсөл-2<br>- Шинэчилсэн журмын төслийг ЭМЯ-нд 01/1837 дугаартай албан бичгээр 2022.09.27-ны өдөр хүргүүлсэн.<br>- ЭМЯ-наас 2022.10.26-ны өдөр 05/4808 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналыг журмын төсөлд тусгаж, ЭЭХХЗГ-ын Даргын зөвлөлийн 2022.12.08-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, шинэчилсэн журмын төслийг ЭМЯ-нд 01/2311 дугаартай албан бичгээр 2022.12.12-ны өдөр хүргүүлсэн. | 90% |
| 1.10 | Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний эрт сэрэмжлүүлэх, эргүүлэн татах журмыг шинээр боловсруулж, батлуулна. | - | Шинээр батлуулсан журам | - | Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний эрт сэрэмжлүүлэх, эргүүлэн татах журмыг шинээр боловсруулж, төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлнэ. | Шинээр боловсруулсан журмын төсөл-1<br>- Журмын төслийг боловсруулж, ХЭЗ-ийн Биологийн идэвхт бүтээгдэхүүний салбар зөвлөлийн 2021 онд хэлэлцүүлсэн.<br>- Иргэдээс шинээр боловсруулсан журмын төсөлд санал авахаар 2022.02.15-ны өдөр байгууллагын цахим хуудсанд сарын хугацаатай байршуулсан.<br>- Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.3.2, захиргааны нөлөөллийн үнэлгээг хийсэн.<br>- ЭЭХХЗГ-ын даргын зөвлөлийн 2022.12.08-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, Эм, эмнэлгийн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.8 дах заалтыг үндэслэн хурлаас гарсан саналыг журмын төсөлд тусгаж, ЭЭХХЗГ-ын даргаар батлуулахаар шийдвэрлэсэн. | |
| 1.11 | Эмнэлгийн эм зүйн албаны үлгэрчилсэн дүрмийг шинээр боловсруулж, батлуулна. | - | Шинээр батлуулсан дүрэм | 2021 онд Эмнэлгийн эм зүйн албаны дүрмийг боловсруулсан. | Эмнэлгийн эм зүйн албаны үлгэрчилсэн дүрмийн төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | Шинээр боловсруулсан дүрмийн төсөл-1<br>- Дүрмийн төсөлд санал авахаар ЭМ-ийн 13 байгууллагын уулзалт зохион байгуулсан. Уулзалтад 22 эмнэлгийн мэргэжилтэн оролцсон.<br>- Иргэдээс санал авахаар дүрмийн төслийг 2022.02.16-ны өдөр, 2022.09.26-ны өдөр тус тус байгууллагын цахим хуудсанд сарын хугацаатай байршуулсан.<br>ЭМЯ-нд хүргүүлсэн дүрмийн төсөл-1<br>- Дүрмийн төслийг ЭЭХХЗГ-ын даргын зөвлөлийн 2022.12.08-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, ЭМЯ-нд 2022.12.12-ны өдрийн 01/2311 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 90% |
| 1.12 | Хяналт шалгалтын хэвлэмэл маягтын загвар, хяналтын хуудсыг боловсруулж, батлуулна. | - | Батлагдсан маягт, хяналтын хуудас | - | Хэвлэмэл маягт, хяналтын хуудсын загварыг боловсруулж, төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | Батлагдсан маягт, хяналтын хуудас-14<br>ЭЭХХЗГ-ын даргын А/11 тушаалаар 14 төрлийн хэвлэмэл маягтыг хавсралтаар, А/113 тоот “Хяналт шалгалтын баримт бичигт нэгдсэн дугаар олгох журам батлах тухай” тушаалыг батлуулан мөрдөн ажиллаж байна. Мөн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль шинэчлэн батлагдах хүртэл МХЕГ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд мэргэжлийн хяналтын газрын тушаалаар батлагдсан 5 хяналтын хуудсыг хяналт шалгалтад ашиглаж байна.<br>- Улсын байцаагчдын байгууллагын харьяалал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор эрүүл мэндийн байгууллагуудад хяналт шалгалт хийх хяналтын хуудсыг өөрчлөн боловсруулсан төслийн жагсаалтыг хавсарган, 01/2902 дугаартай албан бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн. | 100% |
| 1.13 | ЗГҮАХ-ийн 2.1.8. МУХТЖҮЧ-ийн 2.2.7.<br><br>Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний үнийн тандалт, | - | Шинээр боловсруулсан журмын төсөл | - | Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний үнийн тандалт, зохицуулалт хийх журмыг боловсруулж, төслийг Эрүүл | Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний үнийн тандалт, зохицуулалт хийх журмын төсөл-1<br>Журмын төслийн боловсруулах ажлын хүрээнд үнэ зохицуулах аргыг Эстони (Medicinal Products Act 2004), Шинэ Зеланд (Medicines Act 1981 and 1984), Казахстан (Medicines Price regulation rules 2020), Португал (Medicine Act 2006) зэрэг улсын үнийн зохицуулалтын арга болон | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохицуулалт хийх журмыг шинээр боловсруулна. | | | | мэндийн яаманд хүргүүлсэн байна. | ДЭМБ-ын 2020 онд гаргасан “Үнийн бодлогын удирдамж” дээр тусгасан 10 арга, 2021 онд гаргасан “Улс орны эмийн үнийн бодлого-Нөхцөл байдлын судалгаа” дээр тусгасан эмийн үнийг зохицуулах аргатай харьцуулан, давуу болон сул талыг судалж, дүн шинжилгээ хийсэн.<br>Казахстан улсын эмийн үнийн журмыг жишиг болгон МУ-ын эмийн үнийн зохицуулалтын журмын төслийг эхний байдлаар боловсруулсан.<br>Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний үнийн тандалт, зохицуулалт хийх журмын төсөл боловсруулах ажлын хэсгийг ЭЭХХЗГ-ын даргын 2022.11.11-ний өдрийн А/212 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулж, "Эмийн үнийн хяналт, зохицуулалт хийх журам"-ын төслийг танилцуулж, журмын төсөлд санал авах зорилгоор 2022.11.21-ний өдөр ажлын хэсгийн хурлыг зохион байгуулсан. Ажлын хэсгийн 4 гишүүнээс ирсэн саналыг нэгтгэн төслийг боловсруулсан. | |
| 1.14 | Вакцин, биобэлдмэлд цувралын зөвшөөрөл олгох журмыг шинээр боловсруулж, батлуулна. | - | Шинээр батлагдсан журам | - | Вакцин, биобэлдмэлд цувралын зөвшөөрөл олгох журмыг боловсруулж, төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | Вакцин, биобэлдмэлийн цувралын зөвшөөрөл олгох журмын төслийг боловсруулж, газар хэлтсээс 27 саналыг авч нэгтгэн 2022.12.08-ны өдөр Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж. “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалтыг үндэслэн ЭЭХХЗГ-ын даргын тушаалаар батлуулахаар шийдвэрлүүлсэн. | 70% |
| 1.15 | Хүчилтөрөгчийн хангамж, үйлдвэрийн стандартыг шинээр боловсруулна. | 5 сая Улсын төсөв, Төсөл хөтөл-бөр | Боловсруулсан стандартын төсөл | Үндэсний болон олон улсад мөрдөгдөж буй стандартын харьцуулсан судалгааг хийсэн. | Хүчилтөрөгчийн хангамж, үйлдвэрийн стандартыг боловсруулж, төслийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | Хүчилтөрөгчийн хангамж, үйлдвэрийн стандартыг боловсруулах ажлын хүрээнд<br>- “Хүчилтөрөгчийн үйлдвэр, хийн хангамжийн стандарт боловсруулах ажил”-ын удирдамжийг 2022.09.12-ны өдөр батлуулсан.<br>- Монгол болон олон улсад ашиглагдаж байгаа хүчилтөрөгчийн үйлдвэр, хийн хангамжийн стандартыг судалж, 3 стандартыг сонгож, 2022.09.22-ны өдөр НҮБХС-гийн холбогдох мэргэжилтэнтэй цахим уулзалт зохион байгуулан танилцуулсан.<br>- ISO 7396-1:2016 Эмнэлгийн хий дамжуулах хоолойн систем 1-р хэсэг: Эмнэлгийн шахсан хий ба вакум шугам хоолойн систем (Medical gas pipeline systems; Pipeline systems for compressed medical gases and vacuum) стандартыг сонгож, НҮБХС-гийн дэмжлэгээр худалдан авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - 2022.11.21-ний 01/2168 дугаар албан бичгээр 188 хуудас бүхий стандартын орчуулга хийлгэхээр “Мөнгөт Орчлон” ХХК-ийг сонгон 2022.11.29-ний өдрийн ЭЭХХЗГ/22/72 дугаар гэрээг байгуулсан.<br>- Гэрээний дагуу 188 хуудас бүхий стандартын төслийг хүлээн авч 2022.12.12-ны өдрийн 06/2310 дугаар албан бичгээр ШУТИС-ийн Эрчим хүчний сургууль, ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн салбар зөвлөлд хүргүүлэн ирүүлсэн саналын дагуу өөрчлөлт оруулсан.<br>Уг стандартын төслийг 2022.12.14-ний өдрийн даргын зөвлөлийн хурлаар танилцуулж, 2022.12.15-ны өдрийн 01/2322 дугаар албан бичгээр Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. | |
| 1.16 | Амьсгалын аппарат болон унтуулгын аппаратын ерөнхий болон аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлагын стандарт боловсруулна. | 10 сая Улсын төсөв, Төсөл хөтөл-бөр | Боловсруул сан стандартын төсөл | Өвчтөний хяналтын мониторын ерөнхий болон аюулгүй ажиллагаанд тавигдах стандартыг боловсруулж, Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн. | Амьсгалын аппарат болон унтуулгын аппаратын ерөнхий болон аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлагын стандартыг боловсруулж, Стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлсэн байна. | Амьсгалын аппарат болон унтуулгын аппаратын ерөнхий болон аюулгүй ажиллагаанд тавигдах шаардлагын стандартыг боловсруулах ажлыг хүрээнд:<br>- Стандартуудын шинэчлэгдсэн хувилбарыг авахад дэмжлэг хүсэх тухай 2022.05.09-ний өдрийн 01/929 дүгээр албан бичгийг СХЗГ-т хүргүүлж, үнэ төлбөргүй авсан.<br>- Стандартын орчуулга хийх үнийн саналыг авч, 2022.10.23-ны өдрийн ЭЭХХЗГ/22/48 дугаар “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулсан.<br>Тус 2 стандартын нийт 247 хуудас бүхий орчуулгыг 2022.11.12-ны өдөр хүлээн авч, стандартын төсөлд санал авах тухай 2022.11.28-ны өдрийн 01/2192 дугаар албан бичгээр ШУТИС-ийн Эрчим хүчний сургууль, ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн мэргэжлийн салбар зөвлөлд хүргүүлж, ирүүлсэн саналыг стандартын төсөлд тусгаж бэлэн болгосон.<br>Стандарт хэмжил зүйн газрын Стандартчиллын техникийн хорооны 2022.12.20-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэхээр хурлын төлөвлөгөөнд орж батлагдсан. | 90% |
| 1.17 | “Чанарын гарын авлага, менежментийн тогтолцооны журам”-ыг | 2,5 сая Улсын төсөв, Төсөл | Шинэчлэн батлагдсан журам | ISO/IEC 17025:2018 стандартын дагуу итгэмжлэлийг шинээр авсан байна. | ISO/IEC 17025:2017 стандартын дагуу “Чанарын гарын авлага”, менежментийн | Шинэчлэн батлагдсан журам-27<br>ЭЭХХЗГ-н даргаар шинэчлэн батлуулсан:<br>-“Чанарын гарын авлага”-ыг 2022 оны А/16 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинэчлэн батлуулна. | хөтөл-бөр | | | тогтолцооны журам шинэчлэн батлагдаж, Итгэмжлэлийн хүрээг баталгаажуулж, лого тэмдэг ашиглах эрх авсан байна. | -“Удирдлагын тогтолцооны журам”-ыг 2022 оны А/16 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар,<br>-“Анхан шатны бүртгэлийн маягт”ыг 2022 оны А/28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар шинэчлэн батлуулсан.<br>ISO/IEC 17025:2018 стандартын дагуу Чанарын гарын авлага 20 сэдэв, Удирдлагын тогтолцооны журам-24, Бүртгэлийн маягт-200 батлуулсан.<br>2022.04.23-ны өдөр MNS/ISO/IEC 17025:2018 дагуу 4 төрөлд 443 үзүүлэлтээр шинжилгээ хийх итгэмжлэлээ баталгуулж, тэмдэг ашиглах эрх авсан. /Итгэмжлэлийн гэрчилгээ Дугаар TL 172/ | |
| ХОЁР.Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн зохицуулалттай холбоотой тандалт, судалгаа, үнэлгээ хийнэ. | | | | | | | |
| 2.1 | Зах зээл дэх эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус тандалт, судалгаа хийнэ. | - | Тандалт судалгаа хийсэн эм, эмнэлгийн хэрэгслийн тоо | 2021 онд 4 эм, 33 оношлуурт чанар, аюулгүй байдлын тандалт, судалгаа хийсэн. | Зах, зээл дэх эм, вакцины чанар, аюулгүй байдлын тандалт судалгааг хийсэн байна. | Тандалт судалгаа хийсэн эм, биологийн идэвхит бүтээгдэхүүний нийт тоо-257, эмнэлгийн хэрэгслийн тоо-1<br>- Хуурамч, стандартын бус, бүртгэлгүй эмийг илрүүлэх тандалтад 26 нэрийн эм;<br>- Эмийн аюулгүй байдал, гаж нөлөөний тандалтад 90 нэрийн эм;<br>- Зар сурталчилгааны 142 нэрийн эм биологийн идэвхит бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгсэл болох нэг удаагийн амны хаалт 1<br>Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний төлөвлөгөөт 3, төлөвлөгөөт бус 22 тандалт болон 6 удаагийн үнэлгээ хийсэн байна. | 100% |
| 2.2 | Экспортын чиг баримжаатай эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг экспортлоход тулгамдаж буй асуудалд судалгаа хийнэ. | - | Судалгааны тайлан | - | Судалгааг хийж, тайланг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | Судалгааны тайлан – 1.<br>Экспортын чиг баримжаатай эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний мэдээллийг үйлдвэрлэгчдээс авсан. Дараах уламжлалт эмийн үйлдвэрүүд 2022 онд бүтээгдэхүүнээ экспортлосон байна. Үүнд:<br>- Ариун Монгол эмийн үйлдвэр 160 нэрийн, 2958кг, 373 сая төгрөгний өртөг бүхий уламжлалт эм;<br>- Мон-Интра эмийн үйлдвэр 27 нэрийн, 12120 хайрцаг, 76 сая төгрөгний өртөг бүхий уламжлалт эм;<br>- Одь Тан эмийн үйлдвэр 12 нэрийн, 36 кг, 6 сая төгрөгний өртөг бүхий уламжлалт эм;<br>Дотоодын үйлдвэрүүдээс экспорт хийхэд тулгамдаж буй асуудлаар судалгаа авч нэгтгэсэн. Үүнд: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Эм үйлдвэрлэлийн зохистой дадал (GMP)-ын батламж олон улсад хүлээн зөвшөөрөгдөхгүй байна.<br>- Монгол Улсын үндэсний фармакопей, үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл олон улсад хүлээн зөвшөөрөгдөөгүй.<br>- Экспортын бүтээгдэхүүнийг ОХУ, БНХАУ-аар дамжуулан гаргахад хууль эрх зүйн орчин бүрдээгүй.<br>Судалгааны дүнг ЭЭХХЗГ-ын Даргын зөвлөлийн 2022.12.05-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, судалгааны тайланг ЭМЯ-ны БТГ-т 2022.12.09-ний өдрийн 01/2303 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | |
| 2.3 | МУТЖҮЧ-2.2.7, ЗГҮАХ-2.1.8. Үндэсний үйлдвэрүүдийн эмийн түүхий эд, туслах материалын импорт, гааль татварын НӨАТ-ын талаарх сүүлийн 3 жилийн судалгааг хийнэ. | - | Судалгааны тайлан | - | Судалгааг хийж, тайланг Эрүүл мэндийн яаманд тайланг хүргүүлсэн байна. | Судалгааны тайлан-1<br>Дотоодын эмийн үйлдвэрүүдийн 2019-2021 онд импортлосон эмийн түүхий эд, туслах материалд төлсөн гааль болон НӨАТ-ын татварын судалгааг хийж, тайланг ЭМЯ-нд 2022.02.23-ны өдөр цахимаар, 2022.12.15-ны өдрийн А/2324 дүгээр бичгээр ЭМЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. Үүнд:<br>1. Гаалийн татварт<br>- 2019 онд 515,862,942 төг<br>- 2020 онд 805,026,323 төг<br>- 2021 онд 1,066,365,609 төг<br>2. Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-т<br>- 2019 онд 1,049,658,078 төг<br>- 2020 онд 1,650,537,094 төг<br>- 2021 онд 2,255,754,318 төгрөг тус тус төлсөн байна. | 100% |
| 2.4 | 2021 онд ерөнхий гэрээгээр худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн байдалд үнэлгээ хийнэ. | - | Үнэлгээний тайлан | - | Ерөнхий гэрээгээр худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн үнэлгээний тайлан гарсан байна. | Төрийн худалдан авах ажиллагааны газрын Цахим дэлгүүрээс төрийн өмчийн эрүүл мэндийн 132 байгууллагын худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн 2021 оны тайлан мэдээг нэгтгэж, үнэлгээ хийсэн. Үнэлгээний тайланг ЭЭХХЗГ-ын Даргын зөвлөлийн 2022.10.31-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, 2022.12.14-ний өдрийн 01/2318 дугаар албан бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн. Ерөнхий гэрээгээр худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн нийт худалдан авалтад эзлэх хувь 2019 онд 17%, 2020 онд 25% байсан бол 2021 онд 32% болж нэмэгдсэн байна. 2021 онд Цахим дэлгүүрт 235 нэрийн эм, эмнэлгийн хэрэгсэл байршин, 132 төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага 49 тэрбум төгрөгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | захиалга хийж, улсын төсөвт 12,8 тэрбум төгрөгийн хэмнэлт үүссэнээс захиалгын 63%, хэмнэлтийн 95%-ийг КОВИД-19 үед хэрэглэгдэх 10 нэрийн эм, 11 нэрийн түргэвчилсэн болон ПГУ оношлуурын худалдан авалт эзэлж байна.<br>2019-2021 оны хугацаанд хамгийн өндөр үнийн дүнгээр Натрийн хлорид 100мл, 250мл уусмал, хамгийн олон тоо ширхэгээр Аскорбины хүчил тарилгын уусмал, Цефазолин эмийг худалдан авсан байна. Эм, эмнэлгийн хэрэгслийг ерөнхий гэрээнд оруулсан босго үнэ тогтвортой байна. | |
| 2.5 | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалт аюулгүй ажиллагаанд үнэлгээ хийнэ. | 25 сая Улсын төсөв, Төсөл хөтөл-бөр | Үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо | 2016 онд орон нутгийн 21, 2017 онд Эрүүл мэндийн яамны 15 эрүүл мэндийн байгууллагад үнэлгээ хийсэн. | 21 аймгийн нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалт аюулгүй ажиллагаанд үнэлгээ хийсэн байна. | Эмнэлгийн тоног, төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалт, аюулгүй ажиллагаанд үнэлгээ хийх удирдамжийг 2022 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн ЭЭХХЗГ-ын даргын 01/05 тушаалаар батлуулсан. Нийт 35 ЭМБ-д үнэлгээ хийсэн. Үүнд:<br>- Баян-Өлгий, Ховд, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган, Говьсүмбэр, Дундговь буюу нийт 11 АЭМГ, 2 бүсийн оношилгоо, эмчилгээний төв, 9 аймгийн нэгдсэн эмнэлэг, 1 сумын нэгдсэн эмнэлэг, 13 эрүүл мэндийн төвүүд дээр очиж Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бэлэн байдал, ашиглалт, аюулгүй ажиллагаанд үнэлгээ хийсэн ба тус чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>Үнэлгээний явцад цуглуулсан мэдээлэлд үндэслэн үнэлгээний тайланг боловсруулан даргын зөвлөлийн 2022.12.14-ний өдрийн хурлаар танилцуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6 | 2023 онд эрүүл мэндийн салбарт шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн судалгаа хийнэ. | - | Судалгаанд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо | 2021 онд тус судалгаанд төрийн өмчийн 95 эрүүл мэндийн байгууллага хамрагдсан. | 2023 онд эрүүл мэндийн салбарт шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн судалгааг гаргаж, Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн салбарт 2023 онд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн судалгааны ажлын хүрээнд:<br>- Судалгааны асуумж, удирдамжийг 2022.03.11-ний өдөр батлуулж, тус өдрийн 02/01/557, 02/01/558 дугаар албан бу ЭМБ-ад хүргүүлсэн.<br>- Судалгаанд нийт 262 ЭМБ оролцсон. ЭМЯ-ны харьяа-10, НЭМГ-ын харьяа-8, Орон нутгийн БОЭТ, аймгийн нэгдсэн эмнэлэг-19, сумын, сум дундын нэгдсэн эмнэлэг-26, сум, өрхийн эрүүл мэндийн төв-199 ирүүлсэн судалгааг нэгтгэн тайланг 2022.06.30-ны өдрийн 06/1339 албан тоотоор ЭМЯ-нд хүргүүлсэн.<br>- Нийт 258 ЭМБ-д шаардлагатай байгаа 350 гаруй нэр төрлийн 6756 эмнэлгийн тоног төхөөрөмж, 10357 сэлбэг хэрэгслийг худалдан авахад нийт 99,2 тэрбум, өндөр өртөгтэй, нарийн бүтэц үйл ажиллагаатай болон гэмтэлтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийлгэхэд 10,1 тэрбум төгрөг шаардлагатай байна. | 100% |
| ГУРАВ. КОВИД 19-ийн цар тахал болон гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. | | | | | | | |
| 3.1 | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг эмийн зохистой хэрэглээ, аюулгүй байдлын чиглэлээр, сургалт, сурталчилгаа хийнэ. | - | Сургалт болон сургалтад хамрагдсан хүний тоо, Сурталчилгааны хандалтын тоо | 2021 онд 3 удаагийн сургалт, 4 удаагийн сурталчилгаа явуулсан. | (КОВИД-19)-ийн эсрэг эмийн зохистой хэрэглээ, аюулгүй байдлын чиглэлээр улирал тутам сургалт, сурталчилгаа явуулсан байна. | Сургалт-8, хамрагдсан-850 хүн<br>- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хэрэглэх вирусийн эсрэг эм Молнупиравир, Тоцилизумаб, Фавипиравир, Ремдисивир эмүүдийн зохистой хэрэглээ, аюулгүй байдлын чиглэлээр аймаг, нийслэлийн төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэшлийн төв, ӨЭМТ-ийн эмч, эмзүйч нарт 7 удаагийн сургалтыг цахимаар зохион байгуулж сургалтад 825 хүн оролцсон.<br>- Эм, вакцины гаж нөлөөг мэдээлэх, вирусийн эсрэг эмийн идэвхтэй тандалтын үр дүнг танилцуулах, цахим систем (E-reporting)-ийг танилцуулах танхимын сургалтыг ЭМБ-уудын эмзүйн албаны дарга нарыг оролцуулан зохион байгуулсан. Сургалтад 25 хүн оролцсон.<br>Сурталчилгаа-2, хандалт-5600<br>- “Ковид-19 өвчний вакцины ач холбогдол, аюулгүй байдал”-ын талаар 1 видео шторкыг хийж, 2022 оны 2 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар сард байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээсэн. (хандалт-100%)<br>- “Эмийн зохистой хэрэглээ”, “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг эм”-ийн талаар иргэдэд зориулсан мэдээлэллээр 2022.09.09-ний өдөр АШУҮИС-тай хамтран лайв ярилцлага хийн түгээсэн (хандалт-5500) | |
| 3.2 | Коронавируст халдвар (КОВИД-19) вакцин, эм, оношлуурт яаралтай нөхцөлд хэрэглэх зөвшөөрөл олгох, бүртгэх үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Яаралтай нөхцөлд зөвшөөрөл олгохтой холбоотой гаргасан санал, гомдлын тоо | 2021 онд яаралтай нөхцөлд хэрэглэх 7 вакцин, 10 эм, 29 оношлуурыг бүртгэсэн. Санал гомдол гаргалгүй ажилласан. | (КОВИД-19)-үед хэрэглэх вакцин, эм, оношлуурыг журмын дагуу хугацаанд нь бүртгэсэн байна. | Яаралтай нөхцөлд зөвшөөрөл олгохтой холбоотой гаргасан санал, гомдол гараагүй.<br>2022 онд яаралтай нөхцөлд хэрэглэх 1 вакцин, 3 эм, 9 оношлуурыг бүртгэсэн. Үүнд:<br>- Хүний эмийн зөвлөл (ХЭЗ)-ийн 2022.03.23-ны өдрийн хурлаар Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед хэрэглэх 3 нэрийн эмийг хэлэлцүүлж, МУ-ын эмийн бүртгэлд бүртгүүлсэн. Үүнд:<br>  - Фавивир /Фавипиравир/<br>  - Ковифор /Ремдесивир/<br>  - Нинавир / Ремдесивир/<br>- ХЭЗ-ийн 2022.07.07-ны өдрийн хурлаар “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийн 15.5 дахь заалт, ЭМ-ийн Сайдын 2021 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакциныг яаралтай нөхцөлд хэрэглэх зөвшөөрөл олгох журам”-ыг үндэслэн Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг 5-11 насны хүүхдэд зориулсан “Пфайзер-БиоНТех” үйлдвэрийн “Комирнэти” вакцинд яаралтай нөхцөлд хэрэглэх зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэн.<br>- Биобэлдмэл оношлуурын салбар зөвлөл (БОСЗ)-ийн 6 удаагийн хурлаар Коронавируст халдвар (КОВИД-19)-ыг илрүүлэх БНХАУ-ын 7, БНСУ-ын 2 нийт 9 түргэвчилсэн оношлуур шинээр бүртгэж, гэрчилгээ олгосон. Үүнд:<br>  1. SARS-CoV-2 Antigen Test Kit<br>  2. NOVA Test® SARS-CoV-2 Antigen Rapid Test Kit (Colloidal Gold Immunochromatography)<br>  3. PCL Covid-19 Ag Gold<br>  4. SARS-CoV-2 Ag Diagnostic Test Kit (Colloidal Gold)<br>  5. CoviFlu Ag Duo | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6. EZERTM Flu & Covid-19 Antigen Duo Rapid Test<br>7. Sars-CoV-2 Antigen Test Kit<br>8. One Step Test for SARS-CoV-2 Antigen (Colloidal Gold)<br>9. Sars-CoV-2 Antigen Test Kit (DR100%5-5) | |
| 3.3 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурт импортын лиценз олгох үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Эрүүл мэндийн сайдын тушаалаар олгосон импортын лицензийн тоо | 2021 онд Эрүүл мэндийн сайдын 13 удаагийн тушаалаар 255 импортын лиценз олгосон. | Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын импортын хүсэлтийг тухай бүр нь Хүний эмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар импортын лиценз олгосон байна. | Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, оношлуурын дээж, стандарт бодис, тусламжийн бараа зэрэг нийт 310 байгууллагад импортын лиценз олгосон байна. Үүнээс:<br>- ЭМ-ийн Сайдын 2017 оны А/407 дугаар тушаал ‘’Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын лиценз олгох журам’’-ын гамшгийн болон онцгой байдлын нөхцөл үүссэн үед эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм болон яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл оруулах заалтын дагуу ХЭЗ-ийн 12 удаагийн хурлаар нийт 72 байгуулагын (давхардсан тоогоор) 316 нэр төрлийн эмийг хэлэлцүүлж, одоогийн байдлаар ЭМ-ийн Сайдын тушаалын дагуу импортын лиценз хүссэн байгууллагын 40,2% /29 байгууллага/ эм нь 44,6% /141 эм/ лиценз олгогдсон байна. | 100% |
| 3.4 | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын 3 сарын нөөцийг бүрдүүлэхэд хяналт тавьж, зохицуулалт хийнэ. | - | Бүрдүүлсэн нөөцийн хэмжээ | (КОВИД-19)-ын үед нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж, оношлуурын хэрэгцээг 7 хоног бүр тооцоолж, нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан. | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын нөөцийн байдалд тогтмол хяналт тавьж, 7 хоног бүр мэдээ гарган, 3 сарын нөөц бүрдүүлэх арга хэмжээ авсан байна. | Эрүүл мэндийн байгуууллага, ханган нийлүүлэх байгууллагын нөөцийн мэдээллийг 7 хоног бүр нэгтгэн гаргаж, КОВИД-19 шалтгаант хэвтэн эмчлүүлэгчдийн тоо, ПГУ лабораторийн хүчин чадал, улсын 1 өдрийн хэрэгцээнд үндэслэн нөөц хүрэлцэх хоногийг тооцоолж, нөөцийн байдалд хяналт тавьж ажилласан.<br>Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуурын 3 сарын нөөц бүрдүүлэхэд дараах зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:<br>- Эм, эмнэлгийн хэрэгслийн 3-аас дээш сарын нөөц бүрдүүлж ажиллах тухай 02/01/264 дугаар албан бичгийг ЭМБ-д, “Татан авалт хийж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад анхаарч ажиллах тухай” 08/491, 01/911 дугаар албан бичгүүдийг ханган нийлүүлэх байгууллага, холбоодод хүргүүлсэн.<br>- ЭМЯ, ЗТХЯ болон МИАТ ТӨХК-тай хамтран тусгай үүргийн болон хуваарьт нислэгээр 97 тонн, ГХЯ, ЗТХЯ, УБТЗ-тай хамтран төмөр зам болон автозамаар 120 тонн 531 вагон/чингэлэг эм, эмнэлгийн хэрэгсэл, түүхий | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эд, эмнэлгийн тоног төхөөрөмжийг татан авах ажлыг зохион байгуулсан.<br>- 35 ХНБ-ын 47,4 тэрбум төгрөгийн Репо зээлийн хүсэлтийг ЭМЯ, Монгол банканд 02/01/639, 02/01/642, 01/1572 дугаар албан бичгүүдээр хүргүүлж, Монгол банктай 2 удаагийн уулзалт зохион байгуулсан. Монгол банкаас 2022 оны 3 дугаар улирлын ээлжит урт хугацаат репо арилжааг эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, түүхий эд, тоног төхөөрөмжийн нөөцийг дотоодод бүрдүүлэх үйл ажиллагаанд зориулан 10 тэрбум төгрөгийг арилжааны банкуудад олгосон тухай мэдээллийг ХНБ-дад хүргүүлсэн.<br>- Гадаад гүйлгээний хүсэлтийг ханган нийлүүлэх байгууллагуудаас 7 хоног бүр авч, нэн шаардлагатай, тасалдал үүссэн байдлаар нь эрэмбэлэн Монгол банкинд 20 удаагийн албан бичгээр хүргүүлэн ажилласан. Нийт 85 байгууллагын 123.5 тэрбум төгрөгийн гүйлгээний хүсэлтийг Монгол банканд хүргүүлсэн байна.<br>- Давхардсан тоогоор 44 ХНБ, үйлдвэрийн 450 эрүүл мэндийн байгууллагаас авах 53.5 тэрбум төгрөгийн авлагын мэдээллийг ЭМЯ-нд 4 удаа, эрүүл мэндийн байгууллагуудад 3 удаа 01/10-01/64, 01/774, 01/1054, 01/1442-01/1481, 01/184 дугаар албан бичгүүдээр хүргүүлсэн.<br>- Нөөцийн бэлэн байдалд хяналт тавих зорилгоор ЭЭХХЗГ-ын даргын баталсан 2022.07.27-ны өдрийн 01/05 удирдамжийн дагуу Дархан-Уул, Сэлэнгэ, Завхан, Баян-Өлгий, Ховд аймгийн ЭМГ, НЭ, 16 ХНБ, 2 үйлдвэр, 7 сумын ЭМТ, нийслэлийн 5 ЭМБ, 1 ХНБ-ын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлсэн байдалд хяналт үнэлгээ хийж, мэргэжил арга зүйгээр хангасан. Хяналтаар бэлэн бүтээгдэхүүн, түүхий эдийн 1-5 сарын нөөцтэй байсан. | |
| ДӨРӨВ. Хүн амыг чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, эмийн бүтээгдэхүүний чанарт шинжилгээ хийж, зах зээл дэх эмийн чанарын хяналт хийх. | | | | | | | |
| 4.1 | Үндэсний фармакопейн өгүүлэлд үнэлгээ | 20 сая Улсын төсөв, | Үнэлгээний тайлан | Монгол үндэсний фармакопей 2011 оны анхдугаар | Үндэсний фармакопейн өгүүллийн мэдээний | Үнэлгээний тайлан-1<br>ЭЭХХЗГ-ын даргын 2022.10.07-ны өдрийн А/187 дугаар тушаалаар “Монголын үндэсний фармакопейн өгүүлэлд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хийж, шинэчилэх ажлыг эхлүүлнэ. | Төсөл хөтөл-бөр | | хэвлэлтийг мөрдөн ажиллаж байна. Үнэлгээ хийж байгаагүй. | санг үүсгэж, ҮФӨ-д үнэлгээ хийж, тайланг Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай" ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөө, төсөв батлагдсан. Ажлын хэсэг 2022.10.18-ны өдөр хуралдаж, 3 дэд ажлын хэсэгт хуваагдаж үнэлгээний ажил хийгдсэн.<br>Монгол Улсын Үндэсний Фармакопейд нийт 674 шинжилгээний аргын 451 буюу 66.91%-ийг шинэчлэн сайжруулах шаардлагатай, 199 буюу 29.53%-ийг хэвээр үлдээх, 24 буюу 3.56%-ийг хүчингүй болгох санал гаргасан. Үнэлгээний үр дүнг Фармакопейн хорооны 2022.12.08-ны өдрийн 05 дугаар хурлаар хэлэлцүүлж, 2023 онд Монгол Улсын Үндэсний Фармакопейг шинэчлэх шийдвэр гарсан.<br>Үндэсний фармакопейн өгүүлэлд хийсэн үнэлгээний тайланг ЭМЯ-нд 2022.12.14-ний өдрийн 01/2317 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| 4.2 | Эм хангамжийн болон эрүүл мэндийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. | - | -Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллагын тоо<br>-Хүргүүлсэн зөвлөмж | 2021 онд нийт 127 эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 97 зөвлөмж хүргүүлсэн. | Төлөвлөсөн байгууллагад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, дутагдал илэрсэн байгууллага бүрт зөвлөмж хүргүүлсэн байна. | Зөвлөн туслах үйлчилгээг 2022 онд нийт 813 эрүүл мэндийн байгууллагад үзүүлж, зөрчилтэй 402 нэрийн 6237 ширхэг, 11.328.348 төгрөгийн үнэ бүхий бүтээгдэхүүнийг устгуулж, үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 693 байгууллагад 9543 заалт бүхий зөвлөмж хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан.<br>Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байгууллага-813. Үүнд:<br>- Эм ханган нийлүүлэх байгууллага-139<br>- Нийтийн үйлчилгээтэй эмийн сан-520<br>- Эмнэлэг-154<br>- Эрсдэлийн үнэлгээгээр 462 (56,8%) байгууллага бага эрсдэлтэй, 303 (37,2%) байгууллага дунд, 48 (6%) байгууллага их эрсдэлтэйгээр тус тус үнэлэгдсэн.<br>Зөрчилтэй бүтээгдэхүүн-6237<br>- Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх явцад МУЗГ-ын 311 дүгээр тогтоолын хүрээнд байгууллагын дотоод хяналтын журмыг үндэслэн нийт 402 нэрийн 6237 ширхэг, 11.328.348 төгрөгийн үнэ бүхий хэрэглэх хүчинтэй, хугацаа дууссан, улсын бүртгэлд бүртгэгдээгүй бүтээгдэхүүнүүдийг устгуулах арга хэмжээ авсан.<br>- Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах, үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 693 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагад 9543 заалт бүхий улсын /ахлах/ байцаагчийн зөвлөмж хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан.<br>Сургалт-3<br>- Нийслэлийн зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан байгууллагуудын 154 эмч, эм зүйч, мэргэжилтнүүдэд цахимаар салбарын сургалт зохион байгуулсан.<br>- Булган АЭМГ-ын дарга, мэргэжилтнүүдэд “Эмнэлгийн эм зүйн дэглэм, шаардлага, чанар, аюулгүй байдал, хяналтын хуудсанд тусгагдсан асуудал” цахим сургалтыг зохион байгуулсан. Сургалтад-19 хүн оролцсон.<br>Тус аймгийн Эм хангамжийн 36 байгууллагын холбогдох хүмүүст “Эм хангамжийн салбарт мөрдөгдөж байгаа тушаал шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” цахим сургалт зохион байгуулсан. Сургалтад 12 хүн оролцсон. | |
| 4.3 | Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний өргөдөл, хүсэлтээр болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулсан тохиолдолд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийнэ. | - | -Хийсэн хяналт шалгалтын тоо<br>-Арилгасан зөрчлийн тоо | 2021 онд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн нийт 676 өргөдөл, хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийгдсэн. | Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу хяналт шалгалтыг хийж, зөрчлийг бүрэн арилгасан байна. | Тайлангийн хугацаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн 38 өргөдөл, 149 албан бичгийн дагуу 81 байгууллагад хяналт шалгалт хийж, 88 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, 133 зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 34 заалттай 8 албан шаардлага, 99 заалттай 13 зөвлөмжийг хүргүүлж, 60 удаагийн албан бичгээр хариу хүргүүлсэн болно.<br>Хүлээн авсан өргөдөл, гомдлыг задлан авч үзвэл 25 буюу 70 хувь нь Засгийн Газрын 1111 төвд хандсан өргөдөл, гомдол ээзлж байна | 100% |
| 4.4 | Зах зээлд худалдаалагдаж буй хуурамч, улсын бүртгэлд бүртгэгдээгүй, чанар | - | -Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо | 2021 онд 552 байгууллагыг урьдчилан сэргийлэх шалгалтад хамруулан, 113 | Зах зээлд худалдаалагдаж байгаа чанарын шаардлага хангахгүй, улсын бүртгэлд бүртгэгдээгүй эмийг | Хяналт шалгалт хийсэн байгууллагын тоо-11, зөрчил арилгуулсан бүтээгдэхүүний тоо-3016<br>- МУЗГ-ын 311 дүгээр тогтоолоор батлагдсан аж ахуйн нэгж байгууллагын дотоод хяналтын журмыг үндэслэн 11 байгууллагын хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан 224 нэрийн 2861 ширхэг эм, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | стандартын шаардлага хангаагүй эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгсэлд урьдчилан сэргийлэх хяналт хийнэ. | | -Арилгасан зөрчлийн тоо | нэрийн 7637 ширхэг зөрчилтэй бүтээгдэхүүнийг илрүүлсэн. | илрүүлж, зөрчлийг бүрэн арилгасан байна. | эмнэлгийн хэрэгсэл, МУ-ын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй 2 нэрийн 24 ширхэг лаа, нийт 226 нэрийн 2885 ширхэг 183.084.794 төгрөгийн эмийг устгуулж, хяналт тавьж ажилласан.<br>- Чанарын шаардлага хангахгүй, дагалдах бичиг баримтгүй 2 нэрийн 131 ширхэг 143.000 төгрөгийн эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг буцаан татан авалт хийлгүүлсэн. | |
